



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/987

Улаанбаатар хот

Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж,
авлига, хүнд суртлыг бууруулах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.7 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.13 дахь хэсэг, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5 дахь заалт, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 5.2.4 дэх заалт, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.1.2 дахь заалт, 2/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.3.2 дахь дэд заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулиар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авахыг шаардсанаас бусад бүх төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт, шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын албанд бүртгүүлсний үндсэн дээр нийслэлийн нутаг дэвсгэрт чөлөөтэй эрхлэх нөхцөл, боломжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүрдүүлэхийг нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасныг зөрчиж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, батламж /гэрээ/, гэрчилгээ, тодорхойлолт, дүгнэлт, үнэмлэх, гарын үсэг, бусад баримт бичгийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдээс шаардахыг нийслэлийн бүх шатны нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад хориглосугай.

3.Төрийн үйлчилгээг хүнд суртал, шат дамжлагагүй, шуурхай үзүүлэх зорилгоор үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримталж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын албан хаагчдад үүрэг болгосугай:

3.1.хуульд заасан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг холбогдох хууль, журамд заасан хугацаагаар олгох;

3.2.төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг чанд баримтлах, шаардлагагүй тохиолдолд хугацааг сунгахгүй байх, сунгах тохиолдолд хууль, журамд заасан хугацааг хэтрүүлэхгүй байх;

111020004775

3.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг иргэн, хуулийн этгээдийн өргөдөл /нэмэлт баримт бичиг шаардахгүйгээр/-ийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор сунгах;

3.4. төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад байгаа баримт бичгийг хасаж, иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх;

3.5. үзүүлж байгаа бүх үйлчилгээний нэр, төрөл, зохицуулж буй журам, бүрдүүлэх материалын жагсаалт, холбогдох бусад мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн байршуулах арга хэмжээ авч, өөрчлөлт орсон тохиолдолд 24 цагийн дотор шинэчлэх;

3.6. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;

3.7. энэ захирамжийн биелэлтийг харьяа байгууллагын хэмжээнд зохион байгуулж, явц, үр дүнг 14 хоног тутам Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд цахим хэлбэрээр ирүүлж байх.

4. Дараах шаардлагыг хангаж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т даалгасугай:

4.1. үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бодитой эрсдэл, онцгой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэж, борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж буй ажил, үйлчилгээнд хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг 50 хувиар бууруулах;

4.2. хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон хор хохирол учруулснаас бусад тохиолдолд хяналт шалгалт хийхдээ эхлээд илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар иргэн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, албан шаардлага өгөх, албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор гүйцэтгэлийн шалгалт хийж байх;

4.3. хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаа, журмыг чанд мөрдөж, хяналт шалгалтыг давхардуулахгүй байх;

4.4. хяналт шалгалтыг зөвхөн удирдамж, хяналтын хуудсанд заасан асуудлын хүрээнд хийх;

4.5. хяналт шалгалтыг зөвхөн тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн төлөвлөх, хийх;

4.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг 24 цагийн дотор арилгаж, тавьсан шаардлагыг бүрэн биелүүлсэн тохиолдолд тухайн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, давтан шалгалтын дүнг үндэслэн ногдуулсан торгуулийг хүчингүй болгох арга хэмжээ авах.

5. Нийслэлд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох, хууль тогтоомж, стандарт, шаардлагын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нэгдсэн мэдээллийн системийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т үүрэг болгосугай.

6. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн гомдол, маргааныг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Зөвлөлийн ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


7. Энэ захирамжийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Г.Хонгорзул/-т үүрэг болгосугай.

8. Энэ захирамжийг зөрчсөн төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулахыг холбогдох удирдах албан тушаалтнуудад даалгасугай.


9. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг багасгах, эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, хууль тогтоомж, стандарт, шаардлагыг биелүүлж ажиллахыг нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад уриалсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text 'НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА' and 'БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН' along with a central emblem.


Нийслэлийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 29-ны өдрийн
А/ 987 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА,
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын
Захирагчийн Ахлах зөвлөх
- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захираганы удирдлагын хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга;
 - Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга;
 - Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын дарга;
 - “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн гүйцэтгэх захирал;
 - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;
 - Улаанбаатар худалдааны танхимын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/.
- Нарийн бичгийн дарга:
- Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн
11/987 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн гомдол, маргааныг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийн үйл ажиллагаанд энэ журмыг мөрдөнө.

1.2. Зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн үндсэн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь төрөөс бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах талаар баримталж байгаа бодлогын хүрээнд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчсөн талаарх гомдлыг хүлээн авч, хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэх;

2.1.2. жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомж, дүрэм, журмын зөрчил, хийдлийг арилгах талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулж шийдвэрлүүлэх;

2.1.3. жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэх хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон асуудлаар зөвлөмж боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

Гурав. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Зөвлөл Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК болон хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ахлах зөвлөх удирдана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан хувийн хэвшлийн төлөөллийг санхүү, эдийн засгийн салбарын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, ажлын туршлага, ашиг сонирхлын зөрчил үүсч болох нөхцөл байдал зэргийг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

3.3.Зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1.ёс зүй, ашиг сонирхол, хувь хүний нэр хүнд нь зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

3.3.2.ял шийтгэлгүй байх.

3.4.Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:

3.4.1.эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

3.4.2.зөвлөлийн үйл ажиллагаанд хүндэтгэх үзэх шалтгаангүйгээр хоёроос дээш удаа оролцоогүй;

3.4.3.гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг нь тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол гарсан.

3.5.Зөвлөлийн гишүүн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

3.5.1.зөвлөлөөс гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд тайлбарлахдаа хувийн байр сууриа илэрхийлэх;

3.5.2.нийтэд мэдээлээгүй мэдээ, мэдээллийн нууцлалыг алдагдуулах, өөрийн болон бусдын эрх ашигт нийцүүлэн урвуулан ашиглах;

3.5.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа буюу хэлэлцүүлэх асуудлын талаар нийтэд мэдээлэх, зөвлөлийн шийдвэрийг товлосон хугацаанаас өмнө аливаа хэлбэрээр задлах.

Дөрөв.Зөвлөлийн хуралдаан

4.1.Зөвлөл сар бүр хуралдах бөгөөд хуралдааныг зөвлөлийн дарга удирдана. Даргын түр эзгүйд түүний нэр заан томилсон зөвлөлийн гишүүн хуралдааныг удирдана.

4.2.Зөвлөлийн дарга зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.3.Зөвлөлийн гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

4.4.Хэлэлцэх асуудалтай холбогдуулан зөвлөлийн хуралдаанд төрийн захиргааны албан хаагч, шинжээч болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулж болно.

4.5.Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зөвлөлийн дарга батална. Зөвлөлийн гишүүн хэлэлцэх асуудлыг санаачлан хуралд оруулж болно.

4.6.Хуралдааны материалыг хурал эхлэхээс өмнө 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.7.Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сар бүрийн сүүлийн 7 хоногт багтаан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулж байна.

Тав.Зөвлөлийн ажлын алба, түүний чиг үүрэг

5.1.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (цаашид “Ажлын алба” гэх) хариуцна.

5.2.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1.зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт бичиг, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах;

5.2.2.жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн гомдлыг судлан шийдвэрлэх, энэ тухай тайланг зөвлөлийн хуралдаанд цаг тухайд нь танилцуулах;

5.2.3.жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан хуралд оруулах;

5.2.4.хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангах;

5.2.5.зөвлөлөөс гарсан шийдвэрийг холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

5.3.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Ажлын албанаас бэлтгэн тараасан мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах бөгөөд мэдээллийг олшруулах, нийтэд тараах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

Зургаа.Жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам

6.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчид гомдлоо холбогдох баримт материалын хамт Ажлын албанд бичгээр хүргүүлнэ.

6.2.Ажлын алба энэ журмын 6.1-д заасан гомдлыг хүлээн аваад холбогдох баримт, хууль, эрх зүйн орчныг судалж, шаардлагатай гэж үзвэл тухайн жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчтэй биечлэн уулзаж, нэмэлт тайлбар, баримт, мэдээлэл авч болно.

6.3.Ажлын алба шаардлагатай гэж үзвэл тухайн гомдол, маргаанд холбогдох нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас бичгээр тайлбар авна.

6.4.Ажлын алба энэ журмын 6.2, 6.3-т заасан ажиллагааг 14 хоногт багтаан зохион байгуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн даргад танилцуулсны үндсэн дээр түүний зөвшөөрлөөр уг хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.

6.5.Ажлын хэсэг нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөнийг тогтоосон тохиолдолд дараах арга хэмжээний аль нэгийг авна:

6.5.1.зөрчлийг арилгах талаар тухайн байгууллага, албан тушаалтанд албан бичиг хүргүүлэх (тухайн шийдвэр, үйл ажиллагаа ямар хууль тогтоомжийг зөрчсөн талаар болон зөрчлийг арилгах хугацааг тодорхой заасан байна);

6.5.2.тухайн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох саналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулж шийдвэрлүүлэх.

6.6.Жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн гомдлыг хянан шийдвэрлэх явцад хууль тогтоомж, дүрэм, журмын хооронд зөрчил, эсхүл эрх зүйн хийдэл байгаа нь тодорхой болсон тохиолдолд Ажлын алба тухайн зөрчил, хийдлийг арилгах талаар санал боловсруулж, зохих журмын дагуу зөвлөлийн хуралдаанд оруулна.

6.7.Зөвлөл энэ журмын 6.6-д заасан саналыг хэлэлцээд хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар зөвлөмж боловсруулж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулна.

Долоо.Зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх

7.1.Зөвлөлийн шийдвэрийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн зөвшөөрснөөр нийтэд мэдээлнэ.

Найм.Бусад

8.1.Энэ журмыг зөрчсөн буруутай төрийн албан хаагчид хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл хүлээлгэх бөгөөд бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

-----oO-----